

ХАЛААСНЫ ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХАНДАЖ БУЙ ОЛОН НИЙТИЙН ХАНДЛАГА
PUBLIC ATTITUDE TOWARDS ACTIVITIES TO COMBAT THEFT CRIME

*ДХИС-ийн магистрант,
цагдаагийн ахмад Б.Пүрэвдорж
B.Purevdorj - Graduate student,
University of law Enforcement
police chief lieutenant police captain*

Хураангуй. Түүхэн эх сурвалжаас үзвэл ямар ч цаг үед халаасны хулгайн гэмт хэрэг байсан бол өнөөдөр халаасны хулгайн гэмт хэрэг зохион байгуулалттай аж ахуйн нэгж болон хувирч, эдийн засгийн хувьд боломж муутай иргэдийг бүлэглэн нэгтгэдэг гэмт бүлэглэлийн хэмжээнд хүртэл хөгжсөөр байна. Халаасны хулгай нь дэлхийн томоохон хотуудад зонхилж байгаа хэдий ч Дэлхийн бүх улс орны Эрүүгийн хуулинд халаасны хулгайн гэмт хэргийн тухай хууль, эрх зүйн хувьд тодорхой хүлээн зөвшөөрөгдөөгүй байдаг юм байна.

Халаасны хулгайн гэмт хэрэг нь дэлхийн олон улс оронд түгээмэл тохиолддог бөгөөд ихэвчлэн хүн амын нягтаршил ихтэй, аялал жуулчлал хөгжсөн бүс нутаг, хотуудад илүү өргөн тархсан байдаг. Гэсэн хэдий ч, улс орон бүрийн нөхцөл байдал, статистик мэдээлэл харилцан адилгүй байдаг тул дэлхийн хэмжээнд нарийвчилсан харьцуулалт хийхэд хүндрэлтэй юм.

Энэхүү судалгааны тойм өгүүлэлд Монгол Улс дахь халаасны хулгайн гэмт хэргийн төлөв байдал, гарахад нөлөөлж буй хүчин зүйл, халаасны хулгайн гэмт хэрэгт хандах олон нийтийн хандлагыг судалж, уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаар иргэдийн санаа бодол, гадаадын зарим улс орнуудад нэвтрүүлсэн туршлагын талаар товч авч үзсэн болно.

Absract. Historically, pickpocketing has been a crime at all times, but today it has evolved into an organized crime group that targets economically disadvantaged individuals. Although pickpocketing is prevalent in major cities around the world, the criminal code of all countries does not clearly recognize the crime of pickpocketing.

Pickpocketing is common in many countries around the world, and is usually more widespread in densely populated and tourist-rich regions and cities. However, the circumstances and statistics vary from country to country, making detailed comparisons on a global scale difficult. This research review article examines the status of pickpocketing in Mongolia, factors influencing its occurrence, public attitudes towards pickpocketing, and briefly discusses citizens' opinions on prevention efforts and practices introduced in some foreign countries.

Түлхүүр үг. Халаасны хулгайн гэмт хэрэг, иргэдийн хандлага, урьдчилан сэргийлэх ажил, туршлага

Keyword. International airport, parking lot, parking arrangement, traffic flow and direction

Удиртгал. Дэлхийн бусад улс орнуудад ч халаасны хулгайн гэмт хэрэг түгээмэл тохиолддог. Тухайлбал, аялал жуулчлалын төв болсон Европын зарим хотууд, тухайлбал Барселона, Парис, Ром зэрэг газруудад халаасны хулгайн гэмт хэрэг өндөр түвшинд бүртгэгддэг талаар мэдээлэл байдаг. Эдгээр хотуудад халаасны хулгайчид ихэвчлэн

жуулчдыг онилдог бөгөөд олон нийтийн газар, нийтийн тээвэр, аялал жуулчлалын бүсүүдэд үйлдэл гаргадаг байна.

Халаасны хулгай гэдэг нь хүний биед ойр байрлах эд зүйлс (гар утас, түрийвч, үнэт эдлэл гэх мэт)-ийг эзнийх нь анзаарахгүйгээр хулгайлах гэмт хэрэг юм. Энэ төрлийн гэмт хэргийг ихэвчлэн олон хүн цугларсан гудамж талбай, олон нийтийн газарт, хурдан бөгөөд далд аргаар, зохион байгуулалттай бүлэг хүмүүс үйлдэгддэг нь тулгамдсан асуудал болоод байна. Халаасны хулгайн гэмт хэрэг нь дэлхий даяар нийтлэг асуудал бөгөөд иргэдийн анхаарал, сонор сэрэмж, хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа чухал үүрэгтэй юм.

Судалгааны зорилго: Монгол Улс дахь халаасны хулгайн гэмт хэргийн төлөв байдал, гарахад нөлөөлж буй хүчин зүйл, халаасны хулгайн гэмт хэрэгт хандах олон нийтийн хандлагын талаар иргэдийн санаа бодлыг танин мэдэх, гадаадын зарим улс орнуудад нэвтрүүлсэн туршлагыг судалж, өөрийн оронд нэвтрүүлж болох зарим арга замыг эрэлхийлж, үндэслэл бүхий санал боловсруулахад энэхүү судалгааны ажлын зорилго оршино.

Судалгааны зорилт: Энэхүү судалгааны ажлын зорилгыг хангах үүднээс дараах зорилтыг дэвшүүлсэн болно. Үүнд:

- Олон улсын нисэх буудлын дэргэдэх авто машины зогсоол, түүний хэрэгцээ шаардлага, ач холбогдлыг судалж үзэх;
- Монгол Улс дахь халаасны хулгайн гэмт хэргийн төлөв байдлыг судлах
- Халаасны хулгайн гэмт хэрэг гарахад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох
- Халаасны хулгайн гэмт хэрэгт хандах олон нийтийн хандлагын талаар иргэдийн санаа бодлыг танин мэдэх
- Гадаадын зарим улс орнуудад халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр нэвтрүүлсэн туршлагыг судлах
- Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх үндэслэл бүхий санал боловсруулахад чиглэгдсэн, үндэслэл бүхий санал боловсруулах зэрэг болно.

Хүрэх үр дүн: Монгол Улс дахь халаасны хулгайн гэмт хэргийн төлөв байдал, гарахад нөлөөлж буй хүчин зүйл, халаасны хулгайн гэмт хэрэгт хандах олон нийтийн хандлагын талаар иргэдийн санаа бодлыг танин мэдэж, гадаадын зарим улс орнуудад халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр нэвтрүүлсэн туршлагыг судалж, өөрийн оронд нэвтрүүлж болох зарим арга замын талаар саналыг зохих алба, нэгжийн удирдлагад хүргэх явдал болно.

Судалгааны ажлын шинэлэг тал, практик ач холбогдол: Монгол Улс дахь халаасны хулгайн гэмт хэргийн төлөв байдал, уг гэмт хэрэгт хандах олон нийтийн хандлага, гадаадын зарим улс орнуудад нэвтрүүлсэн туршлагыг судалж, өөрийн оронд нэвтрүүлж болох зарим арга замыг эрэлхийлэх чиглэлээр анх удаа судалгаа хийсэн нь энэхүү судалгааны ажлын шинэлэг талыг илэрхийлж байгаагийн зэрэгцээ нэвтрүүлж болох үндэслэл бүхий санал боловсруулсан нь энэхүү судалгааны өгүүллийн практик ач холбогдлыг харуулж байна.

Үндсэн хэсэг. Халаасны хулгай гэдэг нь хүний биед ойр байрлах эд зүйлс (гар утас, түрийвч, үнэт эдлэл гэх мэт)-ийг эзнийх нь анзаарахгүйгээр хулгайлах гэмт хэрэг юм. Энэ төрлийн гэмт хэрэг ихэвчлэн олон хүн цугларсан газарт, хурдан бөгөөд далд аргаар үйлдэгддэг.

"Халаасны хулгай" нь дэлхий даяар тархсан зовлон бөгөөд Энэтхэг зэрэг улс орнуудад танил аюул заналхийлсээр байна (Deshotels, 2013). Халаасны хулгайн гэмт хэрэг

нь хохирогчдод янз бүрийн зовлон зүдгүүр учруулж, хөл хөдөлгөөн ихтэй газрыг ашиглаж, үнэт зүйлсийг хулгайлж авдаг (Nafsila & Abraham, 2021; Du et al., 2016).

Түүхэнд оппортунист гэж үздэг халаасны хулгай нь зохион байгуулалттай аж ахуйн нэгж болж хувирч, эдийн засгийн хувьд боломж муутай хүмүүс бүлгүүдийг бүрдүүлдэг (Staats, 1977). 14-р зууны сүүлчээр "түрийвч" нэрээр үүссэн халаасны хулгай 18-19-р зууны үед Европт эдийн засгийн хэрэгцээ, ажилгүйдлийн улмаас огцом өссөн (Palk, 2006; Hitchcock & Schoemaker, 2010). Халаасны хулгайн гэмт хэрэг тархсан хэдий ч Энэтхэгийн Эрүүгийн хуульд хууль эрх зүйн хувьд тодорхой хүлээн зөвшөөрөгдөөгүй бөгөөд хулгайн гэмт хэргийн өргөн хүрээний хуулинд багтдаг (Шарма, 2019)

Нэг. Халаасны хулгайн гэмт хэргийн төлөв байдал, бусад гэмт хэргээс ялгагдах шинж

Монгол Улсын хувьд халаасны хулгайн гэмт хэрэг сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, 2022 оны эхний 7 сарын байдлаар улсын хэмжээнд хулгайлах гэмт хэрэг 4,395 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2.2 дахин өссөн үзүүлэлт юм. Үүнээс халаасны хулгайн гэмт хэрэг 385 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 2.4 дахин өссөн байна. Эдгээр хэргийн 90 хувь нь нийслэл Улаанбаатар хотод үйлдэгдсэн байна. (Халаасны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлье, n.d.)

2024 оны байдлаар нийслэл хотод 1,330 удаагийн халаасны хулгайн гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд хохирогчдын 61.3 хувь нь эмэгтэйчүүд, 21.2 хувь нь насанд хүрээгүй хүүхдүүд байна. Гэмт хэргийн 45.5 хувь нь 06:00-20:00 цагийн хооронд автобусны буудал болон нийтийн тээврийн хэрэгсэлд үйлдэгдсэн бөгөөд нийт хэргийн 93.5 хувийг гар утасны хулгай эзэлж байна. Халаасны хулгайн гэмт хэргийн хохирогчдын 82.5 хувийг хүүхэд, эмэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд уг гэмт хэргийн 93.5 хувийг гар утасны хулгай, үлдсэн хувийг хэтэвч, зөөврийн компьютер, гэрэл зургийн аппарат болон бусад эд зүйл эзэлж байна. (Халаасны хулгайн гэмт хэргийн хохирогчдын 82.5 хувийг хүүхэд, эмэгтэйчүүд эзэлж байна, n.d.)

Халаасны хулгай нь бусад хулгайн төрлийн гэмт хэрэгтэй төстэй боловч дараах онцлог шинж чанараараа ялгардаг. Үүнд:

1. Нууцлаг, далд үйлдэгддэг. а/Бусад хулгайн гэмт хэргүүд (байшин, машин, дэлгүүрээс хулгай хийх гэх мэт) ихэвчлэн илүү хүч хэрэглэн, шууд бус арга замаар үйлдэгддэг, б/Харин халаасны хулгайч нар маш нарийн, далд арга техник ашиглаж, хохирогчийг анзаарах боломжгүй байхад нь эд зүйлсийг нь хулгайлдаг.

2. Хохирогч гэмт хэргийн хохирогч болсноо шууд анзаардаггүй. Ихэнх хохирогчид эд зүйлсээ алдагдсаныг дараа нь мэддэг бөгөөд үйлдэл хэрхэн хийгдсэн тухай ойлголтгүй байдаг. Энэ нь халаасны хулгайг илрүүлэхэд хүндрэл учруулдаг гэсэн үг юм.

3. Хүчирхийлэлгүйгээр үйлдэгддэг. Халаасны хулгай нь ихэвчлэн хүч хэрэглэлгүйгээр явагддаг. Харин дээрэм, булаалт гэх мэт бусад хулгайн гэмт хэргүүд нь ихэнхдээ хүч хэрэглэн үйлдэгддэг.

4. Олон нийтийн газар үйлдэгддэг

Халаасны хулгай нь хүн амын бөөгнөрөл ихтэй газарт хамгийн их үйлдэгддэг. Тухайлбал, нийтийн тээвэр, зах, худалдааны төв, баяр ёслол, олон нийтийн арга хэмжээ, жуулчдын төвлөрсөн бүсэд үйлдэгддэг. Харин бусад хулгайн төрлүүд (гэр, машин, агуулах гэх мэт) тодорхой объектод чиглэгддэг.

5. Бүлэглэн үйлдэх нь түгээмэл байдаг. Халаасны хулгайч нар ихэвчлэн 2-оос дээш бүлгээр ажилладаг. Тухайлбал, нэг нь хохирогчийн анхаарлыг сарниулах, нөгөө нь эд зүйл

хулгайлах, гурав дахь нь хулгайлсан эд зүйлийг холдуулах гэх мэт ажил хариуцдаг байна. Харин бусад төрлийн хулгайнуудыг ганцаараа эсвэл бага бүлгээр үйлдэх нь элбэг байдаг.

6. Түргэн, шуурхай үйлдэгддэг. Халаасны хулгай хэдхэн секундийн дотор явагддаг бөгөөд хохирогчийн анхаарал суларсан мөчид л үйлдэгдэнэ. Бусад хулгайн төрлийн гэмт хэргүүд харьцангуй илүү их цаг шаарддаг (жишээ нь, гэрт нэвтрэх, сейф задлах, машин хулгайлах гэх мэт).

7. Ихэвчлэн жижиг эд зүйлсийг хулгайлдаг. Халаасны хулгайчид ихэвчлэн бяцхан, үнэ цэнтэй эд зүйлсийг онилдог. Тухайлбал, гар утас, түрийвч, мөнгө, үнэт эдлэл, кредит карт, бичиг баримт зэргийг дурдаж болох юм. Харин бусад төрлийн хулгайчид томоохон эд зүйлс (гэр ахуйн техник, автомашин, тоног төхөөрөмж гэх мэт) рүү чиглэдэг.

Халаасны хулгайн гэмт хэрэг нь нууцлаг, хурдан, хүч хэрэглэлгүй, олон нийтийн газар үйлдэгддэг, ихэвчлэн бүлэглэн ажилладаг, жижиг хэмжээний үнэт эд зүйлсийг онилдог гэдгээрээ бусад хулгайн төрлийн гэмт хэргээс ялгаатай. Энэ төрлийн гэмт хэргийг бууруулахын тулд иргэдийн сонор сэрэмж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа чухал үүрэгтэй.

Хоёр. Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд иргэд олон нийтийн хандаж буй хандлагад хийсэн судалгаа

Хандлага гэдэг нь нөхцөл байдал болон бусад хүмүүсийг тааламжтай ба тааламжгүй аль нэг байдлаар үнэлэх үнэлэлт юм. Харилцаа хандлага хоёр нягт холбоотой бөгөөд харилцааны явцад хандлага мэдрэгддэг. Хандлага үйлдэл болохдоо бодлоор дамжин илэрдэг.(Хандлага ба түүний төрлүүд Нисэхийн сургалтын төвийн номын сан, n.d.)

Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд иргэд олон нийт хэрхэн хандаж байгааг тодорхойлох зорилгоор түүврийн аргаар 66 иргэнийг сонгон авч, анкет асуулгын аргаар судалгаа авч шинжилгээ хийлээ.

Судалгаанд оролцогчдын насны байдлыг авч үзвэл 22 буюу 33.3%-ийг “18-24 нас”, 7 буюу 10.6%-ийг “25-29 нас”, 9 буюу 13.6%-ийг “30-34 нас”, 16 буюу 24.2%-ийг “35-39 нас”, 5 буюу 7.6%-ийг “40-44 нас”, 3 буюу 4.5%-ийг “49-49 нас”, 2 буюу 3%-ийг “50-54 нас”, 2 буюу 3% нь “55-аас дээш насныхан” тус тус эзэлж байх бөгөөд хүйсийн байдлыг авч үзвэл 41 буюу 62.1%-ийг “эмэгтэй”, 25 буюу 37.9%-ийг “эрэгтэй” хүйсийн иргэд оролцжээ.

Боловсролын байдлыг авч үзвэл 49 буюу 74.2% нь “дээд боловсролтой”, 15 буюу 22.7% нь “бүрэн дунд боловсролтой”, 2 буюу 3% нь “бүрэн бус дунд боловсролтой” иргэд эзэлж байна. Судалгаанд оролцогчдын ажиллаж буй байгууллагыг нь авч үзвэл 25 буюу 37.9% “төрийн байгууллага”, 10 буюу 15.2% нь “төрийн бус байгууллага”, 5 буюу 7.6% нь “хувьцаат компани”, 4 буюу 6.1% нь “хувиараа бизнес хийдэг”, 5 буюу 7.6% нь “хувийн аж ахуй эрхэлдэг”, 17 буюу 25.8% нь “ажилгүй иргэд” эзэлж байна.

“Нийслэлд халаасны хулгай гэмт хэрэг хэр их гардаг гэж та бодож байна вэ?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 36 буюу 55% нь “Маш их”, 18 буюу 27% нь “Их”, 12 буюу 18% нь “Дунд зэрэг” гэж хариулсан байна. Харин “Та халаасны хулгайн гэмт хэрэгт өртөж, мөнгө, эд зүйлээ алдаж байсан уу?” гэсэн асуултад 48 буюу 73% нь “тийм”, 18 буюу 27% нь “үгүй” гэсэн хариултыг сонгосон байна.

Дээрхи 2 судалгааны асуултыг бөглөсөн судалгаанд оролцсон иргэдийн хариултаас үзвэл нийслэл хотод халаасны хулгайн гэмт хэрэг Монгол Улсын нийт хүн амын 50 орчим хувь нь оршин суудаг, хүн амын нягтаршил ихтэй, аж ахуйн нэгж, байгууллагын төвлөрөл ихтэй, томоохон зах, худалдааны төвүүд нийслэл хотод хамгийн их бүртгэгддэг нь харагдаж байна.



График №1. Гэмт хэргийн гаралт



График №2. Хохирсон байдал

Дээрх графикаас үзвэл судалгаанд оролцсон иргэдийн 73% нь халаасны хулгайн гэмт хэрэгт өртөж, эд зүйлсээ алдан, гэмт хэргийн хохирогч болж байсан нь уг гэмт хэргийн гаралт өндөр байгааг бататгах нэг хариулт гэж үзэв. /график №2/

“Та олон нийтийн газар үйлдэгдэж байгаа халаасны хулгайн гэмт үйлдлийг харж байсан уу?” гэсэн асуултад 32 буюу 49% нь “тийм”, 28 буюу 42% нь “үгүй”, 6 буюу 9% нь “мэдэхгүй” гэсэн хариултыг өгчээ. Харин “Халаасны хулгайн гэмт хэргийн талаарх мэдээллийг цагдаагийн байгууллагад өгч байсан уу?” гэсэн асуултад 21 буюу 32% нь “тийм”, 41 буюу 62% “үгүй”, 4 буюу 6% нь “санахгүй байна” гэсэн хариултыг тус тус өгчээ.



график №3. Халаасны хулгайн харсан эсэх




график №4. Мэдээлэл өгч байсан эсэх

Дээрхи графикуудаас үзвэл судалгаанд хамрагдсан иргэдийн 50 орчим хувь нь халаасны хулгайн гэмт хэргийг харж байсан бол, дөнгөж 32% нь цагдаагийн байгууллагад мэдэгдэж байсан нь дэндүү бага байгаа нь иргэд, олон нийтийн хандлага энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд бэлэн биш байгааг харуулж байна. /график №3, 4/

“Халаасны хулгайн гэмт хэрэг гарахад ямар хүчин зүйл хамгийн их нөлөөлдөг вэ?” гэсэн асуултад судалгаанд оролцсон иргэдийн өгсөн хариултыг 34 буюу 51.5% нь “халаасны хулгайн гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлага сул, ялын хэмжээ бага”, 31 буюу 47% нь “Ажилгүйдэл”, 28 буюу 42.4% нь “ядуурал”, 26 буюу 39.4% “камерын хяналт хангалтгүй”, 20 буюу 30.3% нь “халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх цагдаагийн алба хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадвар дутмаг”, 18 буюу 27.3 % нь “иргэдийн хараа хяналт сул”, 16 буюу 24.2% нь “халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх иргэд хандлаг, эрмэлзлэл сул”, 13 буюу 19.7% нь “иргэд халаасны хулгайн гэмт хэргийн талаарх мэдээллийг

цагдаагийн байгууллагад өгөх явдал хангалтгүй”, 12 буюу 18.2% нь “халаасны хулгайн гэмт хэрэг гарах орчин нөхцөл их”, 12 буюу 18.2% нь “хүн амын төвлөрөл их” гэсэн хариултуудыг тус тус өгчээ.

График №5. Халаасны хулгайн гэмт хэрэг гарахад нөлөөлж буй хүчин зүйлс



Дээрхи хүснэгтээс харвал иргэд халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх нь цагдаагийн байгууллагын үүрэг гэсэн судалгаанд оролцогчдын дийлэнх нь үзсэн байх бөгөөд энэ нь тэдний уг гэмт хэрэгтэй тэмцэх хандлага ямар байгааг харуулж байна. Түүнчлэн халаасны хулгайн гэмт хэргийн талаарх мэдээллийг цагдаагийн байгууллагад өгөх явдал хангалтгүй, ялангуяа халаасны хулгайн гэмт хэрэгт оногдуулж буй ялын хэмжээ бага байгаа нь хариуцлагын тогтолцоо хангалтгүй хэрэгждэгтэй холбоотой байна.

Халаасны хулгайн гэмт хэрэг гарахад хамгийн их нөлөөлж байгаа хүчин зүйл бол иргэдийн уг гэмт хэрэгт хандаж байгаа хандлагаас хамаарч байгаа нь харагдаж байх бөгөөд иргэд цагдаагийн байгууллагад мэдээлэхгүй байгаа нь уг гэмт хэрэгтэй тэмцэхэд сөргөөр нөлөөлөх нэг хүчин зүйл болж байна. Мөн нийгмийн гаралтай хүчин зүйлүүд цөөнгүй нөлөөлж байна. Тухайлбал, ажилгүйдэл, ядуурал, хүн амын төвлөрөл их байхаас гадна томоохон худалдааны төв, зах, их дэлгүүрүүд их байгаа нь халаасны хулгайн гэмт хэрэгтнүүдэд ажиллах боломжийг бүрдүүлээд байна гэж судалгаанд оролцогчид үзжээ.

Халаасны хулгайн гэмт хэрэг яагаад гараад байгаа талаар тодруулахад судалгаанд оролцогчдын 7 буюу 13.6% нь “халаасны хулгайчид залуужсан”, 14 буюу 21% нь “иргэдийн халаасны хулгайн гэмт хэргийг харсан ч айгаад хэлдэггүй”, 17 буюу 25.8% нь “халаасны хулгайчид бүлгээр зохион байгуулалттай ажилладаг”, 17 буюу 25.8% нь “Халаасны хулгайчид соёлтой боловсон хувцасладаг учраас олны хараанд өртөх магадлал бага болсон”, 17 буюу 25.8% нь “иргэдийн өөрсдийн эд зүйлдээ тавих хяналт сул”, 19 буюу 28.8% нь “халаасны хулгайн гэмт хэргийг харсан мэдээлдэггүй, сөрөг хандлагатай”, 21 буюу 31.8% нь “иргэд юмаа алдсан ч цагдаад мэдэгддэггүй”, 23 буюу 34.8% нь “халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх мэргэшсэн алба хаагчдын тоо цөөрч байгаа”, 25 буюу 25.8% нь “нийтийн тээврийн хэрэгсэлд хяналтын камер хангалтгүй байршуулсан”, 35 буюу 53% нь “халаасны хулгайн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан ял, шийтгэлийн хэмжээ бага” гэж тус тус хариулжээ.




График №6. Гэмт хэрэг гарч байгаа шалтгаан

Халаасны хулгайн гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нь амар хялбар аргаар мөнгө олох хүсэлдээ автсан залуус нэмэгдэж, тэр хэмжээгээр халаасны хулгайчид залуужин өсч байгаа, мөн бүлэг зохион байгуулалтад орсон, залуужсан учраас хувцаслалтын хувьд ялгагдахаа байсан, богино хугацаанд мөнгө олох боломжтой байдаг нь энэ гэмт хэрэг гарах томоохон шалтгаан болж байна. Нөгөө талаараа иргэд, олон нийтийн өөрсдийн өмч хөрөнгөнд тавих хяналт хяналт сул, гэмт хэргийг харчихаад мэдээлдэггүй, эсхүл юмаа хулгайд алдчихаад цагдаагийн байгууллагад мэдэгддэггүй, нийтийн тээвэр болон олон нийтийн газар хангалттай хяналтын камер байршуулж чадаагүй, халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх

чиглэлийн мэргэшсэн алба хаагчдын хүний нөөцийн дутагдалтай байдал гэх мэт маш олон шалтгаан үүнд хамаарч байна.

Халаасны хулгайн гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд ямар ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохистой талаар судалгаанд оролцогчдоос тодруулахад доорхи графикт тусгагдсан хариултуудыг өгсөн байна.



График №.7. Урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ

Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд олон нийтийн зүгээс дараах саналуудыг гаргасан байна. Тухайлбал, 1 буюу 1.5% нь “халаасны хулгайчийн царайг нь олон нийтийн цахим сүлжээгээр цацах”, 2 буюу 3% нь “шууд царайг нь харуулах”, 13 буюу 19.7% нь “Халаасны хулгайн гэмт хэргийн талаарх мэдээллийг төлбөртэй худалдан авдаг болох”, 17 буюу 25.8% нь “Халаасны хулгайн гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг дахин нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулах”, 18 буюу 27.3% нь “Олон нийтийн цахим сүлжээгээр халаасны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зүйн талаар тайлбарлан таниулах ажлыг явуулах”, 27 буюу 40.9% нь “Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх иргэдийн хандлагыг нэмэгдүүлэх”, 34 буу 51.5% нь “Нийтийн тээврийн хэрэгсэлд хяналтын камер суурилуулах”, 43 буу 65.2% нь “Олон нийтийн газар хяналтын камерыг олноор нь байршуулах”, 43 буюу 65.2% нь “Халаасны хулгайн гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангаруулах” гэсэн саналуудыг дэвшүүлсэн байна.

Дүгнэлт. Дээрхи бүх судалгааны үр дүнг нэгтгэн авч үзвэл халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хандлага хангалтгүй, оролцоо муу, урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн байгууллагаас өгсөн заавар, зөвлөмжийг дагаж мөрддөггүй, халаасны хулгайг харсан ч хэлдэггүй, шаардлага тавьдаггүй, өөрөө юмаа

алдсан ч цагдаагийн байгууллагад мэдэгддэггүй зэрэг нь иргэд, олон нийтийн дунд сөрөг хандлага ихээр хадгалагдаж байгаа нь анхаарал татаж байна.

Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэхэд олон нийтийн газар, нийтийн тээврийн хэрэгсэл, автобусны буудал, нийтийн үзвэр үйлчилгээний газруудад хяналтын камер хангалтгүй, уг гэмт хэрэгтэй дагнан тэмцэж буй мэргэшсэн алба хаагчдын тоо буурч байгаа, халаасны хулгайн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлага сул, ял шийтгэлийн хэмжээ бага байгаа зэрэг олон хүчин зүйлс нөлөөлж байна. Халаасны хулгайн гэмт хэрэгтэй зөвхөн цагдаагийн байгууллага, иргэд, олон нийттэй хамтрахын зэрэгцээ шинжлэх ухааны ухаалаг дэвшилтэд программ хангамжуудыг өргөнөөр ашиглан тэмцвэл үр дүнтэй гэж үзэж байна.

Санал. Дээрх дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Олон нийтийн цахим сүлжээ ашиглан халаасны хулгайн гэмт хэрэгтэй олон нийтийн оролцоонд тулгуурласан хандлага өөрчлөх цахим сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулах

2. Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэхэд хиймэл оюун ухаан ашиглан тэмцэх аргуудыг өргөнөөр ашиглах. Тухайлбал:

- Хяналтын камерын ухаалаг систем
 - Хөдөлгөөн, үйл хөдлөлийн анализ – ХОУ нь олон нийтийн газар хүмүүсийн үйл хөдлөлийг хянаж, сэжигтэй үйлдлийг илрүүлэх боломжтой. Жишээлбэл, хэн нэгэн бусдын халаас руу гар дүрж байвал автоматаар анхааруулга өгөх систем хөгжүүлэх боломжтой.
 - Царай таних технологи – Өмнө нь хулгайн хэрэгт холбогдож байсан хүмүүсийг таньж, хяналтын төвд мэдээлэл дамжуулах боломжтой
 - Гар утас, ухаалаг төхөөрөмж ашиглах
 - GPS болон IoT – Гар утас эсвэл ухаалаг түрийвчний байршлыг хянаж, хулгайд өртсөн тохиолдолд эзэнд нь мэдэгдэх боломжтой.
 - Машин сургалт дээр суурилсан сэрэмжлүүлэг – Ухаалаг аппликейшн нь хэрэглэгчдэд тухайн бүс нутагт халаасны хулгайн эрсдэл өндөр байгааг урьдчилан анхааруулах боломжтой.
 - Нийгмийн сүлжээ, өгөгдлийн анализ
 - Гэмт хэргийн халуун цэгийг тодорхойлох – ХОУ нь өнгөрсөн гэмт хэргийн мэдээллийг анализ хийж, аль бүс нутагт халаасны хулгайн гэмт хэрэг их гардаг болохыг тодорхойлж, цагдаа нарт мэдээлэх боломжтой.
 - Хохирогчдын мэдээллийн сан – Иргэд халаасны хулгайд өртсөн тухайгаа мэдээлэх тусгай платформ ажиллуулж, олон нийтийг сэрэмжлүүлэх боломжтой.
3. Халаасны хулгайн гэмт хэргийн талаарх мэдээллийг төлбөртэй авч иргэд, олон нийтийн хандлагыг нэмэгдүүлэх

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. *Халаасны хулгайн гэмт хэргийн хохирогчдын 82.5 хувийг хүүхэд, эмэгтэйчүүд эзэлж байна.* (n.d.). Retrieved March 31, 2025, from https://ubn.mn/p/75506?utm_source=chatgpt.com
2. *ХАЛААСНЫ ХУЛГАЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛБЭ!* (n.d.). Retrieved March 31, 2025, from https://police.gov.mn/a/6102?utm_source=chatgpt.com
3. *Хандлага ба түүний төрлүүд НИСЭХИЙН СУРГАЛТЫН ТӨВИЙН НОМЫН САН.* (n.d.).